

## УЛС ТӨР, ҮЗЭЛ СУРТАЛ

**ИМПЕРИАЛИЗМЫН ХОЛБООТОН ИХ ХАН ҮНДЭСТНИЙ  
ЖАНЖЛАХ ҮЗЛИЙН ТҮҮХЭН ЭХ СУРВАЛЖ**

ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч  
гишүүн **М.И.Сладковский**

**1. Империализм, их хан үндэстний жанжлах  
үзэл бол улс түмний энх тайван, аюулгүй  
байдлын дайснууд мөн**

Ард түмнийг дайн, сүйрэл, өлсгөлөнд, нийгмийг доройтолд учруулдаг монополист капиталын ноёрхолд тулгуурласан капитализм түүхэнд мөхөх тавилантай бөгөөд түүний нийгмийн суурь нь ганхаж, колонийн дарлалын хуучин хэлбэрүүд балран унаж байна.

Ийм нөхцөлд империализм улам нарийн арга хэрэглэх болж, шинэ холбоотон эрэн хайж байгаа бөгөөд колонийн дарлалаас чөлөөлөгдсөн улс орны зах зээлд шургалан орох шинэ нүх сүвийг ашиглах явдал түүний стратегийн гол зорилгын нэг болж байна. Империалист бүлгүүд юуны өмнө АНУ өнөөгийн Хягадыг дсорхи хэдэн шалтгаанаар холбоотноо болж чадна гэж үзэж байна. Үүнд:

а. Өнөөгийн хятадын удирдлага ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хувьд эвлэршгүй байр суурь баримтлаж байна. БНХАУ-ын удирдагчдаас улс орныхоо дотор социализмын хуурамч уриан дор явуулж байгаа бодлого нь социализмын эдийн засгийн үндэс болох нийгэмчлэгдсэн үйлдвэрлэлийн системийг гутааж байна.

б. Эдийн засаг нь хоцрогдмол хэвээр байгаа БНХАУ дэлхийн зах зээл дээр империалист улсуудын хүчтэй өрсөлдөгч болж чадахгүй байгаа ба түүнээс социалист орнууд болон хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн харилцаанд саад учруулж байгаа нь империалист монополиудын дэлхийн зах зээл дээрх ноёрхлыг хөнгөвчилж байна.

в. БНХАУ-аас Азийн орнууд, түүний дотор Энэтхэг, Энэтхэг-Хятадын хойгийн орнуудад явуулж байгаа их хан үндэстний бодлого энэ районд улс төрийн тогтворгүй байдлыг бий болгож, империалист улсуудад уг бүс нутгийн зөрчилтэй байдлыг ашиглах боломж олгож байна.

БНХАУ-ын их хан үндэстний үзэлт удирдлага ч гэсэн империалист улсуудтай ойртон ашиг хонжоо харж, цэрэг-эдийн засгийн чадамж зөвлөлтийн эсрэг үзлийг өөрийн зорилгодоо ашиглах боломж олж байна. Империалист улсуудтай ойртсоноор БНХАУ-ын олж буй ашиг нь доорхи зүйлүүдээр илэрч байна.

а. БНХАУ ойролцоогоор 25 млрд. долларын зээллэг, орчин үеийн зэр зэвсэг авч, худалдаанд АНУ-ын «хамгийн таатай» дэг журам гэгчээс хөнгөлөлт олж байна.

б. Империалист улсууд «зөвлөлтийн эсрэг үзлийг» Египет, Пакистаны харгис дэглэм, Японы болон бусад орны хонзогногч бүлгүүдтэй ойртох явдалд ашиглаж байна.

в. БНХАУ-ын их хан үндэстний үзэлт удирдлага империалист бүлгүүдийн ивээлийн дор хөрөнгөтний хятад судлалыг хятад төвийн үз-

лийн шинжлэх ухааны хуурамч баримтлалаа сурталчлах, хятадтай хөрш зэргэлдээ орших Азийн орнуудын түүхийг гуйвуулахад ашиглах бололцоо олж байна.

БНХАУ-д Дорнод Азийн ард түмний бодит түүхийг гуйвуулж, тэдний түүхийн өвөрмөц онцлог, ард түмний соёлд халдахыг зорьсон «түүхийн» компанит явууллага өргөн явагдаж байна.

Хятадын удирдлага хөрөнгөтний хятад судлаач нарын мэргэжлийн явцуурлыг далимдуулан тэднийг «их хятадыг» мандуулах хэрэгт ашиглаж, улмаар их хан үндэстний өнгөлзлөгийг ул үндэстэй болгохыг оролдож байна.

## **2. Их хан үндэстний жанжлах үзлийн эртний эх сурвалж**

Материаллаг нөхцөл бол амьдралын хэв ёс, хүн төрөлхтний түүхийн тодорхойлодог юм. Түүхэн материализм нийгмийн хөгжлийн үечлэлийг баттай үндэслэж өгсөн билээ. Хөдөлмөрийн хуваарь, ялангуяа газар тариалангийн ажлыг онцгой салбар болгон заагласан нь ард түмний материаллаг болон оюун санааны амьдралын хөгжлийг тодорхойлон, түүнийг хурдасгаж өгчээ. Хятадад эртний хятадын нийгмийг бүрдүүлэгч түүнийг цаашид хөгжүүлэх аятай нөхцөл бүрэлдсэн байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Эртний хятадуудын түүх Шар мөрний тохойц үржил шимтэй газар тархан суусан иньчүүдийн (м.э.ө. 1600-1700 оны үеийн үлгэр домгийн шахам Инь улсын оршич суугчид) үеэс эхэлдэг. Газар зүйн таатай нөхцөлийн улмаас тэдний суугуул нутагт тариалан эрхлэх, гэрийн тэжээмэл амьтан өсгөх явдал хурдсаж, хөрш зэргэлдээх анчин, загасчин болон нүүдэлчин ард түмнээс хурдан хөгжих бололцоотой болжээ.

Материаллаг аж байдлын давуу тал хятадуудыг цэрэг дайны талаар илүү байх нөхцөлийг бүрдүүлж хөрш улсуудын газар нутгийг эзлэн авах, хоцрогдсон ард түмнийг боолчлох явдлыг нь хөнгөвчилж байв. Эртний түүхийн он дарааллын бичигт: «Шан улсын ван Жоу «И» аймгийн (нүүдэлчин аймаг) тоо томшгүй олон хүнийг өөрийн захиргаанд байлгаж Жоугийн (вангийн) боол, олзлогдогсод болгож байв». (Хятадын түүхийн найруулал, редактор Шан Юэ, 29-р тал.) Эрт дээр зед хятадууд соёлын хувьд ч арай давуу хөгжилтэй байв. Тэд Дорнод Азид хамгийн түрүүнд бичиг үсэг эзэмшжээ. Инь-Шангийн үеийн археологийн олдворуудад хятад үсэгтэй яст мэлхийн хуягууд, амьтдын яс байсан нь Хятадад түүхийн эрт дээр үеэс бичиг үсэг байсныг гэрчилж байна. Хятадууд зөвхөн өөрийн ард түмний түүхийг тэмдэглээд зогсоогүй бусад орны түүхийг ч тэмдэглэн хоироожээ. VII-VIII зууны үе хүртлэх Японы түүх хятад үсгээр бичигдэн үлджээ. Хятад бичиг анх бий болсон нь хятадууд бусад ард түмнийг өөрөөсөө дорд үзэх үзэлд хүргэжээ. Тэд хятад биш ард түмнийг «бүдүүлэг» хэмээн үздэг байв. Гэтэл Өмнөд ба Зүүн өмнөд Азийн зарим ард түмэн манай эриний эхэн үед материалын болон оюун санааны соёлын түвшингөөрөө хятадуудаас илүү байв. Хятадууд өөрийн орныг дэлхийн төвд оршиж байгаа мэтээр дүрслэн боддог байсан нь тэд хятадыг «жун го» буюу «дундад улс» гэж нэрлэснээр ч илэрч байна. Хятад улс эргэн тойрон хоцрогдонгуй нүүдэлчин ард түмнээр хүрээлүүлж бусад ард түмнийг (араб, рим, грек) бодвол далай тэнгис рүү бүр хожуу гарсан явдал нь хятадын төр баригчдаас улс орноо ямар ч ул үндэсгүй товойлгож бусад ард түмний бодит байдлыг зөв дүгнэж чаддаггүй болоход нь нөлөөлжээ. Хятад улс эртний дэлхийн соёлын төвүүдээс тасархай байсан нь хятадын нийгмийн хөгжлийг зогсонги байдалд хүргэхэд багагүй нөлөө үзүүлжээ. Мөн хоцрогдонгуй нүүдэлчдийг төлөөлсөн харийн эрх баригчид хэдэн зуун жилээр хятадын

хаан ширээнд гарч төр барьж байсан нь түүний хөгжилд багагүй нөлөөлжээ.

Хятад гадаад ертөнцөөс тасархай, түүний төр баригчдын хоцрогдсон түрэмгий байдлыг түүхийн олон баримт баталж байна. Мин улсын хаан Чэнзу (XV зууны эхэн) Японы эзэн хаанд тушаал зарлиг явуулж захиргаандаа орохыг шаардаж байв. Гэвч Япон улс Хятадын захиргаанд хэзээ ч байгаагүй билээ. Манжийн эзэн хаан Цянь Лун (Гао-зун) Английн хаан Георга III-ыг (Лорд Маккартны элч төлөөлөгч, 1793-1794 он) өөрийн албат хэмээн үзэж байв. Гэтэл энэ үед Английн түрэмгийлэл Хятадын хилд нилээд ойртож ирсэн байв.

Одоогийн Хятадын их хан үндэстний үзлийг баримтлагч эрх баригчид хятадын эртний хаадын нэгэн адил дэлхийн ард түмний сургагч болж бусад тусгаар тогтносон улс оронд «сургамж үзүүлж» байна. Их хан үзэлт Дэн Сяопин ах дүү социалист Вьетнамын хувьд явуулсан бодлого үүнийг гэрчилнэ.

### **3. Хятадын эрх баригчдын түрэмгийлэл ба түүнээс Хятадад учруулсан хор уршиг**

БНХАУ-ын их хан үзэлт эрх баригчид хятадын материалын болон хүний нөөцийг улс орныг цэрэгжүүлэх явдлыг хурдасгах, их хан үндэстний санаархлыг хэрэгжүүлэх зорилтыг шийдвэрлэж чадахуйц агуу их цэрэгжсэн улс болгох зорилгоор цөлмөж байлаа. Тэд ирээдүйн их хан үндэстний хятадын сайн сайхны төлөө хэмээх нэрийдлээр ард түмнийхээ хөгжлийг доод хэмжээнд чөдөрлөн барьж байна.

Үүнтэй холбогдуулан өнгөрсөн үеийн хятадын түрэмгийллээс хятадын ард түмэнд учруулж байсан хор уршгийг дүгнэж үзэх хэрэгтэй юм. «Жань го» (байлдаант улсууд) (м.э.ө. 403-221 он)-ын үеийн 6 вант улсын (Цинь, Хань, Жао, Вэй, Чу, Янь) өөр хоорондын дайн байлдааны улмаас харгис Цин Шихуаны (Цинь улсын анхны эзэн хаан) удирдлагаар анхны төвлөрсөн эзэн хаант Цинь улс бүрэлдэн тогтжээ. Одоогийн хятадын өмнөд (Гуандун, Гуанси) мужуудын нутаг дэвсгэр дээр байсан гарал үүслээрээ Вьетнамтай нэг эртний Наньюэ улсын эсрэг буюу өмнө зүг рүү эзлэн түрэмгийлэх дайн явуулсны үр дүнд Цинь улс бүрэлдэн тогтсон түүхтэй. Газар тариалан, загас агнуур, мал аж ахуй (үхэр, гахай, хонь) эрхэлдэг байсан Наньюэгийн ард түмнийг түрэмгийлэн эзлэх үед тэд цэргийн давуу талтай байв. Цинь улс умард зүгт хийсэн эзлэн түрэмгийлэх дайнд амжилт олж чаддаггүй байв. Умард зүгийн нүүдэлчин ард түмэн цэрэг, дайны хувьд хятадуудаас илүү хүчирхэг байв. Цинь улс Хүннү нартай дайтахдаа хамгаалах байр суурь баримталж байв. Хятадын хойт талын хилийг заасан цагаан хэрэм бол умард зүгийн нүүдэлчдээс хамгаалах зорилгоор баригджээ. Хятадын хаадаас умард ба өрнө зүгийн хөрш зэргэлдээ орнууд руу хийж байсан дайн хятадын ард түмнийг ихээхэн сүйрэлд учруулж байв. Хятадын хаад зарим нэгэн нүүдэлчин ард түмнийг (хүннү, монгол, зүрчид) өөрийн талд татаж, тэдний тусламжтайгаар цаашдын түрэмгийлэл явуулж байсан үед л амжилт олж байв.

Эртний Хан улсын (м.э.ө. 206-м. э. 220) У Ди хаан (м.э.ө. 140-86) эзлэн түрэмгийлэх дайн явуулж хятадын хил цагаан хэрэмнээс хальж, Дорнод Туркестан, Дундад Ази руу тэлжээ. Дайны улмаас Хятад улс хоосорч, улмаар гурван вант улсад (Вэй, Шу, У) хуваагдав. Үүний зэрэгцээгээр хятадад түрэмгийлэн орсон умард ба баруун зүгийн улсууд хятадын хаан ширээг эзлэн авав. Тан улсын үед (618-907) хятадын цэргүүд цагаан хэрэмнээс хойших хөрш орнуудыг Хятадад нэгтгэсэн юм. Гэвч энэ түрэмгийлэл Хятадыг сулруулж, таван вант улс болгон (907-950) бутрааж, харин хятадын хаан ширээг умард зүгийн Кидан улс (Ляо

улс, 937-1125) эзэмшиж байв. Кидан нарыг Умард Хятадаас зүрчид нар хөөн гаргаж, хятадын Сун улсыг урагш нь шахаж, зүрчид нар Хятадын хаан ширээг эзэмшив. (Цзинь улс, 115-1264). Зурчидийг Хятадаас монголчууд хөөн гаргаж улмаар хятадын бүх газар нутаг монголын хаадын захиргаанд орж, Юан улс (1280-1367) байгуулагдав.

Монгол хаадын хоорондын тэмцлээс болж монгол гүрэн задарч, хятадын Мин улс байгуулагдав. (1380-1644). Мин улсын төр баригчид монголын түрэмгийлэлд нэрвэгдсэн зэргэлдээх орнуудыг ашиглан Цинь, Хан, Тан улсын үеэс уламжлагдан ирсэн эзлэн түрэмгийлэх бодлогыг үргэлжлүүлж, урьд өмнө хятадын харьяанд байсан орнуудыг хятадад нэгтгэхийг оролдож байв. «Мин улсаас манж нартай хийх дайны зарлага бүхлээрээ тариачдын нуруун дээр тохогдож байв» гэж түүхч Шан Юэ тэмдэглэжээ. (Хятадын түүхийн найруулал, редактор Шан Юэ, 468-р тал) «Ляодуны татвар» гэгч цэрэг дайны алба татвар нь улсад их хэмжээний дарамт үзүүлж, хятадын ард түмний дургүйцэл төрүүлж байв. «Мин улсын эцсийн жилүүдэд ноёлогч ангийн эрх баригчид улс орныг хоосолж, газар, мөнгө), баялгийн хойноос улайран хөөцөлдөж, ард түмнийг тонон дээрэмдэж... байсан нь гар урлал, газар тариалангийн хөгжилд ноцтой саад учруулсан юм.» (мөн тэд. 457-р тал)

Цэрэг дайны хөлд үрэгдэн хоосорсон эдийн засгийн хувьд хоцрогдсон Хятадыг манжийн булаан эзлэгчид харьцангуйгаар амархан элэлсэн юм. 1644-1911 онуудад хятадын хаан ширээнд манжийн эрх баригчид заларч Чин улс ноёрхож байв.

#### **4. Хятадын удирдагчдаас явуулсан түрэмгийлэл эдийн засгийн хөгжлийг саатуулж, хятадын олон улсын байр суурийг сулруулав**

Хятадын эзэн хаад түрэмгийлэл явуулж, хөрш зэргэлдээх орнуудын өргөн уудам газар нутгийг эзлэн авсан нь улс орны эдийн засгийн хөгжилд саад учруулж, улс төрийн эв нэгдлийг сарниулав. Хятадад эзэн хаант төр ноёрхож байсан сүүлийн мянган жилийн дотор хятадын хаад хаан ширээгээ зөвхөн 300-гаад жил барьжээ. Харин бусад 700-гаад жилд нь хөрш зэргэлдээх орнуудаас хятадын төрийг барьж байв. Дундад зууны хятадад феодалын нийгмийн байгуулал, улс төрийн зогсонги байдал ноёрхож, улс орон нь дэлхийн бусад улсаас хөндийрч байсан нь Хятадыг тухайн үеийн хөгжилтэй улс орнуудаас мэдэгдэхүйц хоцрогдоход хүргэв. Баруун европын улсуудыг хятадын Өмнөд, Зүүн Өмнөд эрэгт нэвтрэн орж ирэх үед Хятад улс Энэтхэг-хятадын хойгийн орнууд, Солонгосыг өөрийн харьяанд барьж байх чадалгүй болсон байв. Хятадаас эдгээр орнуудын хувьд баримталж байсан түшмэг, хараат болгох систем тэдний хөгжлийг саатуулж байсан учир хятадын эзэн хаад тэдгээр орнуудын ард түмнээс дэмжлэг олж байсангүй. Өрнөдийн капиталист орнууд түүнчилэн Япоп улс хятадын харьяанд байсан Өмнөд ба Зүүн Өмнөд Азийн орнуудыг амархан эзэлж байв.

Хятадын баримталж байсан түрэмгийлэн эзлэх, тусгаарлах бодлого Хятадыг бүрмөсөн сулруулсны улмаас хятад улс империалист улсуудын хагас колони орон болжээ. Тэргүүний социалист орнуудын дэмжлэг, тэдэнтэй тогтоосон холбооны ачаар хятад улс үндэсний тусгаар тогтнол, мөн олон улсын тавцан дээр тусгаар тогтнох эрхээ олж авсан юм.

Хятад улс дэлхийн дэвшилтэт хүчнээс холбоогоо таслаж, империалист улсуудтай сүлбээлдэх бүртээ хямралд орж байсан юм. 1920 оны сүүл 30-аад оны үед, дэлхийн хоёрдугаар дайны дараахи жилүүдэд ийм байдалд орсон юм.

## **5. БНХАУ-ын маоист удирдлага бол их хан үндэстний эзлэн түрэмгийлэх бодлогыг өвлөн авагчид мөн**

БНХАУ-ын маоист удирдагчид өөрсдийн бодлогыг явуулахдаа хятадын өнгөрсөн үеийн түүхэн туршлагыг харгалзаж үзэхгүй байна. Тэд зөвхөн, эзлэн түрэмгийлэх «амжилттай» явууллага, газар нутгийн өнгөлзлөгтэй ходбоотой хэсгийг нь авч байгаа ба харин эзлэн түрэмгийлэх явууллагаас болж хятадад учирсан сүйрлийн хор уршгийг санахыг ч хүсэхгүй байна.

Мао Зэдун эзлэн түрэмгийлэх аян дайнд гавьяа байгуулж байсан баатрууд жишээлбэл эртний хятадын харгис эзэн хаад (Цинь Шихуан ди), зальхай, бялдууч эрх баригчдыг (Цао Цао) үлгэр жишээ баатрууд болгон дурсаж байв.

Ард түмний үлгэр домгийн баатрууд бол эзлэн түрэмгийлэх дайны баатрууд байгаагүй харин дотоодын харгис ёс дэглэмийн эсрэг тэмцэгчид байсан юм. Үүнд:

а. Жуг э Лян (181-234). «Гурван улсын» үеийн (220-280) дайны алдарт жанжин, ардын баатар, Шу улсын хааны зөвлөгч байхдаа хүн ардад газар тариалан эрхлүүлж, үр тариа тариулдаг байв. Ард түмнийг амраахын тулд боомтуудыг хаажээ. (Шан Юэ, 122-р тал).

б. Йо Фэй (1103-1141) ардын домогт баатар, ард түмэн улс орны аз жаргал шударга ёсны төлөө тэмцэгч байсан бөгөөд Сун улсын даргис хааны ордныхны гарт зовлонтойгоор амь үрэгджээ. Йо Фэм ард түмнийг сайн сайхан аз жаргалтай байлгахын төлөө санаа тавьдаг, энэрэнгүй үзэлтэй жанжин хэмээн алдаршжээ. Тэр «Ард иргэдийн орон байрыг устгаж байснаас хүйтэнд хөлдөж үхсэн нь дээр, дээрэм хийж байснаас өлсөж үхсэн нь днэр» гэдэг уриа баримталж байв. (Шан Юэ, 326-р тал).

Мао Зэдун Цин Шихуаны харгислалыг дүгнэхдээ: Цин Шихуан-ди бол 460 күнзийн сургаалтныг амидаар булшилсан. Бид түүнээс хамаагүй хол түрүүлжээ. Бид цэвэрлэгээ хийхдээ хэдэн арван мянган хүнийг хороосон. Бид яг арван Цин Шихуаныг орлож чаджээ... Биднийг Цин Шихуанууд, засгийн эрхийг хууль бусаар булаагчид хэмээн харааж байна. Бид энэ бүхнийг хүлээн зөвшөөрч байна. Харин ч энэ талаар бага юм хийсэн, бүр ч их юм хийж болно гэж бид үзэж байна. (ХКН-ын VIII их хурлын II чуулган дээр Мао Зедуны хэлсэн үг. 1958 оны тавдугаар сарын 3).

Мао Зэдун харгислал, хүчирхийллийг магтан сайшааж байсан нь 196 онд Хан улсын хаан ширээг хууль бусаар булааж авсан Цао Цао-г хэрхэн үнэлж байснаас харагдаж байна. (Шан Юэгийн редакторласан) Хятадын түүхэнд Цао Цаог «Суй Жоугийн таван хошуунд аллага таллага явуулж... хэдэн зуун мянган эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг алж, хүүрийг нь Сышуй голд хаясан» (Шан Юэ, 11-р тал) хайр найргүй залхаан цээрлүүлэгч байсан хэмээн тодорхойлж байна. Тэгэхэд Мао Зэдун:... «Цао Цао дайн явуулж чаддаг байсан. Цао Цао бол Хан улсын эзэн хаан Сяньдиг» эмэгтэй хүнээс төрж, эмэгтэй хүнээр хүмүүжигдсэн» (эмэгтэй хүн шиг эелдэг зөөлөн-М. И.) гэж загнаж байсан нь зөв» гэжээ. (1958 онд Бэй- дайхэгийн зөвлөлгөөн дээр Мао Зедуны хэлсэн үг).

Мао Зэдун болон түүний үе залгамжлагчдын гадаад бодлогод эртний хятадын их хан үндэстний түрэмгийллийн бусад шинж чанарууд («дайсны гараар дайсныг бариулах», «хоёр барыг ноцолдуулчихаад уулын оройгоос ажиглах») давтагдаж байна. Сун улсын хаан байсан Хуйзун Хятадын сул доройг мэдээд дайнч зүрчид нарыг киданчуудтай (1115) хийх тэмцэлд ашиглаж байв. Мөн Өмнөд Сун улсын хаан байсан Ли Зун (1234) монголын хаадтай холбоо тогтоон Зүрчидийн эсрэг дайтаж байв. Одоо

бидний үед Мао түүний залгамжлагчид социалист хамтын нөхөрлөлийн орнуудын эсрэг тэмцэхдээ эртний эзэн хаадаас «дундад улсын» (жун го) хүчин чадлыг бататгахыг оролдож байсны нэг адил АНУ болон бусад империалист улсууд, харгис дэглэмүүдтэй холбоо тогтоож байна. Маоистууд хятадын түүхийн бодит туршлагыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Хятадын эзэн хаад хүчирхэг гүрнүүдтэй холбоо тогтоож байсан тэр үед улс, ард түмнээ хохиролд учруулж, эцсийн эцэст Хятад «холбоотнуудынхаа» захиргаанд ордог байв.

Мао болон түүний үе залгамжлагчид хөрш зэргэлдээ орнуудынхаа хувьд эзлэн түрэмгийлэх бодлого явуулахдаа Өмнөд ба Зүүн өмнөд Азийн ард түмнийг арьс, угсаатны нэг төрөл болгож, нэгдмэл угсаат модны «иш» нь хятад, бусад ард түмэн энэ модны «салаа мөчир» мэтээр үзэж түүнийгээ нотлохыг оролдож байна.

Энэ хуурамч «онолоо» ул үндэстэй болгохын тулд маоист түүх судлал түүхийн шинжлэх ухааны үзэл санаа, үйл явдлын дүгнэлт зэргийг үгүйсгэж, хятадын түүхийг илэн далангүй гуйвуулж байна. Маоистууд энэ «онолыг» БНХАУ-аас социалист Вьетнамын эсрэг явуулсан түрэмгийллийг зөвтгөх зорилготой гаргажээ. Модны «иш» нь «салаа мөчиртөө» сургамж өгөхөөр шийджээ.

х х х

Маоист удирдагчдын их хан үндэстний түрэмгийлэх үзэл хятадын эртний харгис эзэнт улсуудын харш уламжлалд үндэслэж ирсэн юм. Гэвч тэдний үзэлд хятадын түүхийн туршлага бүхэлдээ тусгагдсан биш бөгөөд их хан үндэстний үзэл нь хятадын эрх баригчдын балмад бодлогын уршгаар хүнд хэцүү зовлон зүдүүр туулсан хятадын ард түмний үндсэн эрх ашигт харшилж байна. Их хан үндэстний түрэмгийлэх үзэл дэлхийн ард түмэнд аюул занал учруулж байна. БНХАУ-ын одоогийн удирдлага хятадын эдийн засгийн хоцрогдмол байдлыг хүлээн зөвшөөрч эдийн засгийн энх тайван уралдааны замаар дэлхийд тэргүүлж чадахгүйгээ мэдэж байна.

Маоистууд дэлхийн тэргүүний хөгжилтэй орнуудыг дайнаар сүйрүүлж, дэлхийд тэргүүлэхийг бодож байна. Дэлхийн дайн түүний дотор атомын дайнаар дотоод дахь улс ардын аж ахуйн хямралыг шийдвэрлэхийг маоистууд бодож байгааг харгалзахгүй байж бодохгүй юм.

Хятадын хүн ам бараг миллиард хүрч байна. Нийгмийн үйлдвэрлэлийн тустай хөдөлмөрт хэдэн зуун сая нь оролцохгүй буюу хагас оролцож байна. Энэ асуудлыг улс орныхоо нөөц баялгийг шинжлэх ухааны төлөвлөгөөтэй, ард түмнийхээ эрх ашигт зориулж, үр ашигтай ашиглах замаар социализм шийдвэрлэж чадна.

Орос хэлнээс орчуулсан  
**Н. Алтанцэцэг**

ИСТОРИЧЕСКИЕ ИСТОКИ ВЕЛИКОХАНЬСКОГО  
ГЕГЕМОНИЗМА-СОЮЗНИКА ИМПЕРИАЛИЗМА

**(Резюме)**

В своей статье автор выявляет, причины сближения империалистических кругов, прежде всего США, с нынешним Китаем, и- «выгоды» для КНР, получаемые от сближения с империалистическими странами.

Китайское руководство, пользуясь профессиональной ограниченностью буржуазных синологов, пытается использовать их для прославления «великого Китая», для обоснования великоханьских притязаний.

Истоки великоханьского гегемонизма уходят своими корнями в глубь веков. Благоприятные материальные условия способствовали не только становлению древнего китайского общества, но и социально-экономическому, военному культурному развитию Китая. Это способствовало самовозвеличению ханьцев, порождало у них искаженное представление о других народах. Неспособность реально оценить роль и положение других народов объясняется тем, что Китай на материке оказался в окружении более отсталых кочевых народов, находился в стороне от древних центров мировой цивилизации, и на океанские просторы вышел значительно позднее других народов.

Агрессивная политика правителей китайских династий, основанная на великоханьском гегемонизме, имела пагубные последствия для самого Китая. Из этого автор делает вывод о том, что экспансионизм китайских правителей приводил к застою в китайской экономике и ослаблению его международных позиций.

Всякий раз, когда правительство Китая порывало с прогрессивными силами мира и вступало в союз с империалистическими государствами, Китай оказывался в критическом положении. Нынешние китайские руководители продолжают реакционную агрессивную политику, унаследованную от великоханьского гегемонизма китайских правителей, без учета всего исторического опыта Китая. Они берут ту его часть, которая связана с «успешными» завоевательными походами, с территориальной экспансией, но не хотят видеть катастрофические последствия китайского экспансионизма для китайского народа. Цитируя слова Мао Цзэдуна о его отношении к деспотизму императоров древнего Китая, автор подтверждает умышленное унаследование нынешним руководством Китая великоханьского гегемонизма. Во внешней политике нынешнего китайского руководства копируются и многие другие повадки великоханьских экспансионистов древнего Китая.

Мао и его последователи вступают в союз с США и другими империалистическими государствами и реакционными режимами для борьбы со странами социалистического содружества, уподобляясь древним императорам в стремлении утвердить могущество «срединной империи» (чжунго).

Великоханьский экспансионизм маоистского руководства основывается на реакционных традициях древних китайских империй, но он не отражает весь опыт китайской истории, он также не отвечает коренным интересам китайского народа, испытавшего так много горечи от безрассудства правителей.